



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 08 өдөр

Дугаар A/462

Улаанбаатар хот

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
дүрэм, зохион байгуулалтын бүтцийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрэм”-ийг нэгдүгээр, “Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн зохион байгуулалтын бүтэц”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн орон тоог Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Б.Амгаланбаяр)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Эрдэнэтуяа)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/305 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


САЙД



Ж.ЧИНБҮРЭН

141252324

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 12
дугаар сарын 08 өдрийн 462 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Зоонозын өвчин судлалын үндэсний төв (цаашид “Төв” гэх) нь зоонозын өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан улсын хэмжээнд зохион байгуулах, халдварын эрсдэлийг бууруулах, хүн амыг өвчлөл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүрэг бүхий тусгай мэргэжлийн төв мөн.
- 1.2. Төв Монгол Улсын хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- 1.3. Төв нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шууд удирдлагад харьяалагдан ажиллана.
- 1.4. Төв нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлоготой уялдсан байгууллагын стратеги төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлнэ.
- 1.5. Төв нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, харилцах данстай байна.
- 1.6. Төвийн нэр, үйлчилгээний хамрах хүрээг илэрхийлсэн бэлгэдэл, тугтай байна.
- 1.7. Төв нь Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу цагдаа, дотоодын цэргийн хамгаалалт бүхий Улсын онц чухал объект болно.
- 1.8. Төвийн оноосон нэр: Зоонозын өвчин судлалын үндэсний төв
 - Албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, 18131, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо;
 - Утас: 976-70282859;
 - Цахим шуудангийн хаяг: nczd@nczd.gov.mn.
 - Цахим хуудасны хаяг: nczd.gov.mn
- 1.9. Төвийн нэрийг англи хэлээр “National Center of Zoonotic Diseases” гэж орчуулна.

ХОЁР. ТӨВИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Алсын хараа: Зоонозын өвчинтэй тэмцэх, сэргийлэх чиглэлээр Номхон далайн баруун бүсийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хамтын ажиллагааны төв байна.

Эрхэм зорилго: Шинжлэх ухааны шинэ дэвшилтэт технологи, инновацийг мэргэшсэн хүний нөөцийн чадавхтай хослуулан Монгол Улсын хүн амыг зоонозын өвчний эрсдлээс сэргийлэх.

2.1 Төвийн зорилт:

- 2.1.1 Шинжлэх ухааны дэвшилтэт технологийг үе шаттай нэвтрүүлж, үндэсний хэмжээнд болон төвийн үйл ажиллагаанд өргөнөөр ашиглах;
- 2.1.2 Төвийн хүний нөөцийн ур чадварыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэргэжлийн тусламж, үйлчилгээг нэгсэн удирдлага, арга зүйгээр хангах;
- 2.1.3 Улсын хэмжээнд зоонозын өвчний эрсдэлээс сэргийлэх, өвчний дэгдэлтийн үед голомтод эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах;
- 2.1.4 Зоонозын халдвараас урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанаржуулах чадавхыг бэхжүүлэх

2.2 Төв нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

- 2.2.1. Хууль, хүний эрхийг дээдлэх, ил тод байх;
- 2.2.2. Мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлсэн байх;
- 2.2.3. Ёс зүй, харилцаа хандлагыг эрхэмлэж, хариуцлагатай байх;
- 2.2.4. Хүний эрүүл мэнд, хувь хүн, байгууллага, төрийн нууцтай холбоотой мэдээллийн нууцыг чандлан хадгалах;
- 2.2.5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 2.2.6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олон улсад болон үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, эмнэлзүйн зааврыг ашиглаж үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд ханган ажиллах;
- 2.2.7. Тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчдэд чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах;
- 2.2.8. Манлайлал, хөгжлийг эрхэмлэсэн суралцагч хамт олон байх.

ГУРАВ. ТӨВИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Төв нь дараах эрхтэй:

- 3.1.1. Зоонозын халдварт өвчний асуудлаар улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, эмнэлзүйн заавартай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- 3.1.2. Үндэсний хэмжээний ариутгал, халдваргүйтгэл, мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн арга хэмжээг удирдан зохион байгуулах;
- 3.1.3. Төв нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, хүний болон материаллаг нөөц, төсвийг бүрдүүлж, зохих хууль, тогтоомж, журам, дүрмийн дагуу захиран зарцуулах, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал тавьж шийдвэрлүүлэх;
- 3.1.4. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран явуулах, хурал, зөвлөгөөн, сургалт, семинар зохион байгуулах, ном товхимол, зөвлөмж, заавар гаргах, нийтийн хүртээл болгох;
- 3.1.5. Гадаад, дотоодын ижил түвшний байгууллагуудтай хамтын ажиллагааг

- өргөжүүлэн, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа хийх, туршлага солилцох асуудлаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж гэрээ, хэлэлцээр, санамж бичиг байгуулах;
- 3.1.6. Мэргэжлийн онцлог асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнд мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгаа, сэрэмжлүүлэг өгөх, шаардлага тавих;
- 3.1.7. Зоонозын өвчин судлалын чиглэлээр төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах;
- 3.1.8. Төв нь хууль, тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн дагуу тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;
- 3.1.9. Хууль, тогтоомжоор олгогдсон бусад эрх.
- 3.2. Төв нь дараах үүрэгтэй:
- 3.2.1. Төв нь чиг үүрэг, эрхэм зорилго, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангах;
- 3.2.2. Үндэсний хэмжээнд зоонозын өвчнийг тандах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан зохион байгуулах, халдварын эрсдлийг бууруулах, хүн амыг өвчлөл, эндэглоээс урьдчилан сэргийлэх, зоонозын өвчний байгаль дахь тархалт цар хүрээ, идэвхжлийг тогтоох чиглэлээр лавлагаа шатлалын төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлж, мэргэжлийн аргазүйгээр хангах;
- 3.2.3. Төв нь аймаг, нийслэлийн салбар Зоонозын өвчин судлалын төвүүдэд мэргэжлийн аргазүйн дэмжлэг үзүүлэх;
- 3.2.4. Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, тандалтын стандарт, удирдамж, заавар, арга аргачлал боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- 3.2.5. Төв нь тусламж, үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авч, шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, ирсэн санал гомдолд дүн шинжилгээ хийж, залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 3.2.6. Төв нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг үндэслэл, тооцоо судалгаанд тулгуурлан боловсруулах, батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтааж, байгууллагын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай хуулиуд болон бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж, хэрэгжүүлэх;
- 3.2.7. Төрийн өмчийг үрэгдүүлэх, үнэгүйдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтээх зэрэг аливаа эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, бүртгэл, ашиглалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх;
- 3.2.8. Албан хаагчдын нийгмийн баталгаа, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах, мэргэжил, ур чадварт тохирсон цалин хөлс олгох,

- ажлын бүтээмж, үр дүнд суурилсан урамшуулал олгох, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах;
- 3.2.9. Албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, сахилга хариуцлагыг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, хэвшил болгох арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;
- 3.2.10. Төв нь үйл ажиллагаандаа авлига авах, өгөх, албан тушаалын байдлаа аливаа хэлбэрээр урвуулан ашиглах хууль бус үйлдэл, үйл ажиллагааг хориглох, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах;
- 3.2.11. Жендэрийн тэгш байдлыг хангах, бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, хүний эрхэд ээлтэй орчин бүрдүүлж ажиллах;
- 3.2.12. Тусгай хэрэгцээт иргэний эрхийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль, тогтоомжийн дагуу бүрдүүлсэн байх;
- 3.2.13. Хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх;
- 3.2.14. Эрүүл мэндийн багц хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, нийтэд сурталчлах;
- 3.2.15. Хууль, тогтоомжид заасан бусад үүрэг.

ДӨРӨВ. ТӨВИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 4.1. Төвийг Захирал удирдана. Захирал нь гадаад, дотоод үйл ажиллагаанд төвийг төлөөлнө.
- 4.2. Төвийн удирдлагын тогтолцоо нь Захирал, Удирдлагын зөвлөлөөс бүрдэнэ.
- 4.3. Төвийн албадын дарга нар нь өөрийн хариуцсан чиг үүргийг захирлын удирдлага дор гүйцэтгэж тайлагнан, хариуцлага хүлээнэ.
- 4.4. Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгж (цаашид “нэгж” гэх) нь алба байна. Нэгжийн удирдлага нь тухайн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллана.
- 4.5. Төвийн захирал нь нэгжийн удирдлага, бусад төлөөллийг оролцуулсан Удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг батална.
- 4.6. Төвийн захирал тушаал, Удирдлагын зөвлөл нь шийдвэр гаргана.
- 4.7. Төв нь эрх бүхий байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн дагуу Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо болон бусад шаардлагатай чиг үүрэг бүхий байнгын, түр хороо, зөвлөлийг байгуулан ажиллуулна.

ТАВ. ТӨВИЙН САНХҮҮЖИЛТ

- 5.1. Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
 - 5.1.1. Улсын төсөв;
 - 5.1.2. Үндсэн (хууль, тогтоомжоор зөвшөөрсөн төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого) болон үндсэн бус (хууль, тогтоомжид нийцүүлэн олсон бусад орлого) үйл ажиллагааны орлого;
 - 5.1.3. Төсвийн тухай хуулийн дагуу гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж, төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын орлого;
 - 5.1.4. Хууль, тогтоомжид заасан бусад эх үүсвэр.
- 5.2. Төв нь төсөв, санхүүгийн үр ашигтай удирдлагыг нутагшуулж, төсөв, санхүүгийн эрсдэлийг бүрэн тооцож, өр, авлагагүй ажиллана.
- 5.3. Төв нь санхүүжилт, эд хөрөнгийг төвийн зорилго, зорилт, холбогдох хууль, тогтоомж, энэ дүрэмд нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулан ашиглаж, ил тод байдлыг хангана.
- 5.4. Төв нь өөрийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үндсэн хөрөнгө бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, актлах саналаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 5.5. Төвийн эд хөрөнгийн тооллогыг Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тогтоосон хугацаанд, холбогдох журмын дагуу явуулна.
- 5.6. Төв нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гүйцэтгэж, аудит хийлгэж, аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангана.
- 5.7. Төв нь өөрийн эд хөрөнгө, санхүү, нягтлан бодох бүртгэл, тооцоонд тавих өөрийн болон хөндлөнгийн хяналтыг зохих хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

ЗУРГАА. ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- 6.1. Төвийг гадаад, дотоод хамтын ажиллагаанд Төвийн захирал төлөөлнө.
- 6.2. Захирлын гадаад, дотоод албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ.
- 6.3. Захирлын түр эзгүйд түүний албан үүргийг Захиргааны албаны дарга хэрэгжүүлнэ. Хэрэв Захиргааны албаны дарга эзгүй бол Захирал өөрийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан тушаалтныг томилно.
- 6.4. Албан хаагчдыг гадаад, дотоодод албан томилолтоор ажиллуулах, суралцах асуудлыг төвийн захирал шийдвэрлэнэ.

- 6.5. Гадаад орны эрүүл мэндийн байгууллага, төвтэй хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулах замаар төвийн албан хаагчдыг сургах, дадлагажуулах, Олон улсын хуралд оролцох, хамтарсан судалгаа хийх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 6.6. Төв нь төрийн захиргааны төв байгууллагаас чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа бусад байгууллагатай уялдуулан ажиллана.
- 6.7. Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

ДОЛОО. ТӨВИЙН ЗАХИРЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 7.1. Төвийн захирал нь Эрүүл мэндийн сайдтай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд зааснаас гадна дор дурдсан эрхтэй. Үүнд:
- 7.1.1. Төвийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, төвийг бүрэн хэмжээгээр төлөөлөх;
 - 7.1.2. Удирдлагын зөвлөлийн бүтэц, ажиллах журмыг батлан, удирдан чиглүүлэх;
 - 7.1.3. Хууль, тогтоомж, бусад дүрэм, журмаар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал, шийдвэр гаргах;
 - 7.1.4. Төвийн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийг тодорхойлж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ойрын болон хэтийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих;
 - 7.1.5. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн эрх зүйн орчин болон хэтийн төлөвлөлттэй уялдуулан төвийн ажилчдын тоо, цалин хөлсийг тогтоох;
 - 7.1.6. Нэгжийн дарга болон ажилтнуудыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх, бусад тушаал шийдвэрүүдийг гаргах;
 - 7.1.7. Ажилтнуудын албан тушаалын тодорхойлолт батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, гэрээг цуцлах, дуусгавар болгох.
- 7.2. Төвийн захирал нь Эрүүл мэндийн сайдтай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд тусгагдснаас гадна дор дурдсан үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 7.2.1. Хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг төвийн хэмжээнд зохион байгуулах, үйл ажиллагааны үр дүнг бүрэн хэмжээгээр хариуцах;
 - 7.2.2. Төвийн алсын хараа, хэтийн зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан тодорхойлсон стратеги төлөвлөгөөг салбарын хэмжээнд дэвшүүлсэн бодлого шийдвэртэй нийцүүлэн боловсруулан, батлуулж хэрэгжүүлэх;
 - 7.2.3. Төсвийн ерөнхийлөн захирагчаар жил бүр төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг салбарын урт, дунд, богино хугацааны бодлого, байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан батлуулж, хэрэгжилтийг хангаж, хагас, бүтэн жилээр тайлагнах, ил тод мэдээлэх;

- 7.2.4. Төвийн, жил бүрийн төсвийн төслийг нотолгоонд үндэслэн боловсруулах үйл ажиллагааг удирдлага, аргазүй, зохион байгуулалтаар ханган ажиллах;
- 7.2.5. Батлагдсан төсөв, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан орон тоо, цалингийн санг зохицуулан ажиллах;
- 7.2.6. Эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагааны тогтвортой, сахилга баттай, үр ашигтай байдлыг хангах, өр, авлагагүй ажиллах;
- 7.2.7. Үндсэн хөрөнгө болон бараа, материалын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж, эдийн засгийн үр ашигтай байдлыг хангах;
- 7.2.8. Төвийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааг мэргэжлийн аргазүйн удирдлагаар хангах, хяналт тавих, уялдуулан зохицуулах;
- 7.2.9. Эмнэлгийн санхүү, төсөв болон бусад үйл ажиллагааны тайлан, мэдээний үнэн зөв байдлыг хариуцах;
- 7.2.10. Зоонозын өвчин судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, өвчлөл, эндэгдлийн тандалтын үндэсний тогтолцоо бүрдүүлж, тандалт судалгааны чиглэлээр бусад эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн аргазүйн дэмжлэг үзүүлэх;
- 7.2.11. Зоонозын халдварын талаар иргэдийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулж, үр дүнг тооцож, мэдээ, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
- 7.2.12. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн, хамтарсан төсөл хөтөлбөрийг салбарын хөгжлийн бодлого төлөвлөлттэй нийцүүлэн боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;
- 7.2.13. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн эрх зүйн орчин болон хэтийн төлөвлөлттэй уялдуулан төвийн зүгээс үзүүлэх тусламж, үйлчилгээний цар хүрээ, тоо хэмжээг хүн амын хэрэгцээ шаардлагад үндэслэн төлөвлөх;
- 7.2.14. Зоонозын өвчин судлалын чиглэлээр төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтыг зохион байгуулалтаар хангах;
- 7.2.15. Ажилтнуудын цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлаар гаргасан санал, хүсэлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх;
- 7.2.16. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, үйл ажиллагааны ил тод байдал, жендэрийн мэдрэмжтэй байдлыг ханган, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах;
- 7.2.17. Ажлын байран дээрх дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;
- 7.2.18. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үед ажиллах байгууллагын тохиолдлын удирдлагын тогтолцоо, гамшгийн шуурхай багийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, төлөвлөгөөг тухай бүр тодотгон баталж, шаардлагатай тохиолдолд идэвхжүүлэх ажлыг зохион байгуулах.

НАЙМ. ТӨВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖИЙН ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ

- 8.1 Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгж нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 8.1.1 Холбогдох хууль, тогтоомж, тушаал шийдвэр, стандарт, дүрэм, журмыг хэрэгжүүлэх, мөрдөж ажиллах;
 - 8.1.2 Төвийн алсын хараа, эрхэм зорилгодоо хүрэхэд чиг үүргийн хүрээнд харилцан уялдаа холбоотой хамтран ажиллах;
 - 8.1.3 Эрхэлсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны үр дүнг захирлын өмнө хариуцах, тайлагнах;
 - 8.1.4 Төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйг чанд сахиж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, авлигаас ангид ажиллах;
 - 8.1.5 Хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.
- 8.2 **Захиргааны алба:** Төвийн нэгжийн үйл ажиллагааны харилцан уялдаа холбоог хангах, хурал зөвлөгөөнийг зохион байгуулах, төлөвлөгөөний тайлагналт, хэрэгжилтэд хяналт тавих, хүний нөөцийн хөгжил, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт, албан хэрэг хөтлөлт, албан хаагчдын нийгмийн хамгаалал, ажиллах орчин, хууль эрх зүйг мөрдүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, соён гэгээрүүлэх үүргийг хэрэгжүүлнэ.
- 8.3 **Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын алба:** Зоонозын өвчний байгаль дахь тархалт, цар хүрээ, идэвхжил, эрсдлийн түвшинг тогтоох, эрсдлийн дагуу бүсчлэх, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг мэргэжлийн удирдлагаар хангах, хүн амын дунд тандалт, судалгаа хийх, эрсдлийн түвшинг тогтоох, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 8.4 **Лавлагаа лабораторийн алба:** Хүн амын дунд гарсан зоонозын өвчний шалтгаан, эх үүсвэрийг тодорхойлох, тохиолдлыг баталгаажуулах, лабораторийн тандалт хийх, эрдэм шинжилгээ, судалгаа, үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлэх ажлыг үндэсний түвшинд зохион байгуулах, Зоонозын өвчин үүсгэгч бичил биетний өсгөвөр, омог, эерэг сорьцыг баталгаажуулах, өсгөвөр эерэг сорьцын сан бүрдүүлэх, баяжуулах, зоонозын өвчний онош зүйн лавлагаа тусламж, үйлчилгээний чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Олон улсын лавлагаа лабораторийн чанарын хяналтад хамрагдаж, сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлагыг ханган ажиллана.
- 8.5 **Чанарын хяналт, биоаюулгүй байдлын алба:** Зоонозын өвчний тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагаа төлөвлөх,

зохион байгуулах, хэрэгжүүлэх, үйлчлүүлэгч, ажилтан, албан хаагчдын аюулгүй байдалд хяналт тавих, дэмжин туслах, арга зүйн зөвлөгөө өгөх, халдварын сэргийлэлт, хяналтыг бэхжүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, иргэд, байгууллагаас ирсэн санал, гомдол, хүсэлтийг шийдвэрлүүлэх, эргэн мэдээлэх, ёс зүйн болон бусад хороо, зөвлөл, албадуудтай хамтран ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 8.6 **Биоүйлдвэрлэл, ариутгал, халдваргүйтгэлийн алба:** Зоонозын халдварт өвчний оношилгооны тэжээлт орчин, будаг урвалж, биобэлдмэлийг үйлдвэрлэн үндэсний төв болон салбар төвүүдийн хэрэгцээнд нийлүүлэх, төвийн цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал, угаалгын үйл ажиллагааг хангах, голомтын болон урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийн үйл ажиллагааг хариуцан ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 8.7 **Сургалт, эрдэм шинжилгээ, гадаад хамтын ажиллагааны алба:** Зоонозын салбарт нэвтэрч буй олон улсын шинэ туршлага, инноваци, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх санал, зөвлөмж боловсруулах, эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлтийг хариуцах, хурал, сургалт, семинар зохион байгуулах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, зоонозын халдварт өвчний асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 8.8 **Цахим хөгжүүлэлтийн алба:** Үндэсний төвийн мэдээллийн техник, технологийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хариуцах, мэдээллийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалт, нууцлалыг хангах, шаардлагатай програм хангамжийн шийдлийг боловсруулах, цахим шилжилтийн стратеги төлөвлөх, Зоонозын халдварт өвчний тандалт судалгаа тусламж, үйлчилгээ, хариу арга хэмжээний үйл ажиллагааг хиймэл оюун ухаанд суурилсан шийдлийг хөгжүүлэн ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 8.9 **Санхүү, хангамж, нөөцийн алба:** Төвийн санхүү, эдийн засаг, төсвийн бодлогыг тодорхойлж шилэн дансны ил тод байдлыг хариуцах, байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг хууль, дүрэм, журмын дагуу явуулах, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулах, өдөр тутмын гүйлгээг хийх, бүртгэх, тайлагнах, өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, бүртгэлийг хариуцаж, хөрөнгийн зүй зохистой харьцаа, үр өгөөжийг дээшлүүлэх, нөөцийн агуулахад гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тэдгээрийн түүхий эд, вакцин биобэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйтгэлийн бодис, урвалж, оношлуурыг хадгалахаас гадна тайван цагт олон улсын байгууллагын хандив тусламжаар ирсэн болон улсын хэмжээнд нэгдсэн байдлаар худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

8.10 **Зөвлөл, хороод:** Төв нь Мэргэжлийн зөвлөл, Эрдмийн зөвлөл, Ёс зүйн дэд хорооноос гадна дараах орон тооны бус зөвлөл, хороо, дэд хороодтой байна.

Үүнд:

- 8.2.1. Мэргэжлийн зөвлөл нь Зоонозын өвчний талаарх дунд болон урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах, тандах, хянах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зөвлөн туслах, мэргэжлийн зөвлөмжөөр хангах чиг үүрэгтэй.
- 8.2.2. Эрдмийн зөвлөл нь судалгаа, эрдэм шинжилгээ судалгааны ажлын чиглэл, зорилтыг тодорхойлох, ажлын явц, үр дүнг хэлэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 8.2.3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо нь байгууллагын түвшинд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудлаар санал, дүгнэлт, зөвлөмж, шийдвэр гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус хороо байх бөгөөд байгууллагын түвшинд ёс зүйн асуудлаар сургалт, сурталчилаа, аян санаачлан зохион байгуулах, соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 8.2.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл нь онц чухал объектод гэмт хэрэг хийхээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль, дүрэм, журам, бодлогыг сурталчилан таниулах, албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг судалж, дүн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 8.2.5. Жендерийн дэд хороо нь жендерийн эрх тэгш байдлыг хангах, жендерийн асуудлуудыг шийдвэрлэх, жендерийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой чиг үүргийг хэрэгжүүлнэ.

ЁС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санаачилгаар салбарын бодлого чиглэлтэй уялдуулан дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулна.
- 9.2. Төвийн саналыг үндэслэн Эрүүл мэндийн тушаалаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 9.3. Энэхүү дүрэм нь Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталснаар хүчин төгөлдөр болно.
- 9.4. Төвийн дүрэм хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлснээр төвийн нийт албан хаагчид дагаж мөрдөнө
- 9.5. Энэхүү дүрэмд тусгагдсанаас бусад асуудлыг холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгээр зохицуулна.

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 1-р дугаар сарын 28-ны өдрийн 1/4 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

